



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 501

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 40 дүгээр зүйлийн 40.1, 41 дүгээр зүйлийн 41.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтууд, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /А.Эрдэнэтуяа /-д даалгасугай

САЙД



Н.УДВАЛ

003107

Эрүүл мэндийн сайдын  
оны 12 сарын 30 өдрийн  
тоот тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэл

| № | Байгууллагын нэр                      | Үйл ажиллагааны чиглэл                                                                                                |
|---|---------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Универсаль мед ХХК                    | Универсаль мед – Төв эмнэлэг                                                                                          |
| 2 | "Сити-Энержи"                         | Улаанбаатар мед эмнэлэг тусгай мэргэжлийн төв<br>/Бөөр судлалын чиглэлээр/                                            |
| 3 | Мөнхийн тун ХХК                       | Ариутгал халдваргүйтгэлийн бодис импортлох,<br>ханган нийлүүлэх, худалдах                                             |
| 4 | Солармед ХХК                          | Ариутгал халдваргүйтгэлийн бодис импортлох,<br>ханган нийлүүлэх, худалдах                                             |
| 5 | Медлайн групп ХХК                     | Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур багаж тоног<br>төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган<br>нийлүүлэх, худалдах |
| 6 | Монголиан медикал сервис<br>групп ХХК | Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез,<br>эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх,<br>үйлдвэрлэх, худалдах  |
| 7 | Мерит ХХК                             | Эм үйлдвэрлэх /шахмал, үрэл, капсул, галены<br>бэлдмэл/                                                               |
| 8 | ЭМЖЖ ХХК                              | Эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж,<br>дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх,<br>худалдах              |